



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/14

Мандалговь

Ус ашиглуулах зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 107 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг “Хөх дэл” хайлуур жоншны хүдэр олборлох “ФЛЮМОН” ХХК-ний технологид ашиглах зориулалтаар 38188,8 м³/жил, ашиг олох зориулалтаар 3060 м³/жил, Ногоон байгууламжид 1125 м³/жил, зам талбайн усалгааны зориулалтаар 9360 м³/жил усыг 1 жилийн хугацаагаар ашиглахыг “ФЛЮМОН” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. “ФЛЮМОН” ХХК-ний ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ажиллахыг усны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

3. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.5 дахь заалтад заасны дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг “ФЛЮМОН” ХХК-ний захирал (Д.Нансалмаа)-д үүрэг болгосугай.

4. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн дагуу заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг “ФЛЮМОН” ХХК-ний захирал (Д.Нансалмаа)-д даалгасугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА

Tuhsaaj A.docx

482401043